



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 4118

Бэрх хот

Хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дугаар заалт, Захирагчийн зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн №04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотын Казак иргэдэд үндэстний Наурызын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж 650.000 (Зургаан зуун тавин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах 650.000 (Зургаан зуун тавин мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас хууль, дүрэм журмын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 036

БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 03 дугаар сарын 20

Дугаар 04

Бэрх хот

Хурал 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутад Захирагчийн өрөөнд эхлэв.

Хуралд: Хотын Захирагч Ч.Энхжавхлан, Захирагчийн орлогч Н.Бахыт, Захирагчийн ажлын албаны дарга Э.Мягмарсүрэн, Захирагчийн ажлын албаны Нягтлан бодогч Г.Осгонжаргал, Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Н.Мичидмаа, Аж ахуй нэгжийн төлөөлөл Б.Содонцэцэг, Иргэдийн төлөөлөл Д.Цэндсүрэн нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

Хэлэлцэх асуудал:

1.Бэрх хотын Казак иргэдэд үндэстний Наурызын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх тухай

Сонссон нь:

Ч.Энхжавхлан: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хурлаар Бэрх хотын Казак иргэдэд үндэстний Наурызын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх ажил зохион байгуулна. Энэ ажлын зардалд нийт 650.000 төгрөгийн төсөв хэрэгтэй байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Б.Содонцэцэг: Казак иргэддээ чиглэсэн хүндэтгэл үзүүлэх ажил тул дэмжиж байна.

Н.Мичидмаа: Тус ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 650.000 төгрөгийг Захирагчийн нөөц сангийн зардлаас гаргах саналтай байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Д.Цэндсүрэн: Иргэдийн зүгээс энэхүү арга хэмжээг зохион байгуулахыг дэмжиж байна.

Г.Осгонжаргал: Саналыг дэмжиж байна.

Э.Мягмарсүрэн: Дэмжиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Бэрх хотын Казак иргэдэд үндэстний Наурызын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх шаардлагатай 650.000 (Зургаан зуун тавин мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас гаргахыг зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Хурал 16:00 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

С.О.О

Б.СОЁЛ-ЭРДЭНЭ